



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 01/198

Жавхлант

**Хурдан морины уралдааны талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.10, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 18.1.6, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 41 дүгээр тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” батлах тухай А/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүсэж болзошгүй тул хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ, бооцоот тэмцээн зохион байгуулахыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч, Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан, Жавхлантын хурд уяачдын холбооны тэргүүн нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР